



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/585

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41.дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Ховд аймагт зохион байгуулагдах Баруун бүсийн утга зохиолын II чуулганы үйл ажиллагааны зардалд 4870 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зардалд зориулагдах 4870 000 төгрөг /дөрвөн сая найман зуун далан мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.35 дахь заалтын “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих” төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Баруун бүсийн утга зохиолын II чуулганыг орон нутагт өндөр хэмжээнд зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-т хариуцуулсугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/585 Чх
02 02904

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр
сарын 13-ны өдрийн А/585 дугаар
захирамжийн хавсралт



БАРУУН БҮСИЙН УТГА ЗОХИОЛЫН II ЧУУЛГАНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /мян төг/	Нийт үнэ /мян төг/
Нэг. Наадмын зардал				
1	Яруу найргийн онцлох бүтээлүүдийн шагнал	5 хүн	500.000	2.500.000
3	Ном товхимол хэвлүүлэх	800 ш	2962.5	2 370 000
НИЙТ ЗАРДАЛ				4870 000

-oOo-